

# НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

2018.04.18

Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “*Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэл, их засвар, өргөтгөл /Улаанбаатар/*”-ийн *Багц-2* буюу *Шинэ яармаг хорооллын дулааны магистраль шугамын /гэр хорооллоос төв зам дагуу/ БУА*

Тендер шалгаруулалтын дугаар: *ЭХЯ/201812001*

*Эрчим хүчний яам* нь эрх бүхий тендерт оролцогчдоос “*Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэл, их засвар, өргөтгөл /Улаанбаатар/*”-ийн *Багц-2* буюу *Шинэ яармаг хорооллын дулааны магистраль шугамын /гэр хорооллоос төв зам дагуу/* БУА-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:**

*Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017/-н аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй дүнгийн 70 хувиас багагүй байна.*

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** *Тухайн багцад санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна.*

**Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** *Сүүлийн 3 жил буюу “2015, 2016, 2017”*

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** *“тийм”*

**Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:** *03.5.2 “250-350°C, 16-40 кгх/см<sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны угсралт, засвар үйлчилгээ” /Эрчим хүчний яам/*

**Зураг, төсөл боловсруулах байгууллага нь:** *03.9.9 0.7-40.0 кгх/см<sup>2</sup> даралттай шугам, хоолой, ЦТП-ны ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах /Эрчим хүчний яам/*

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Үүнд:

36300000 /гучин зургаан сая гурван зуун мянган төгрөг/

Тендерийг *2018 оны 05 дугаар сарын 18 -ны өдрийн 14 цаг 00 минутаас* өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг *2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 14 цаг 30 минутад* нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.  
Чингисийн өргөн чөлөө. Эрчим хүчний яам.  
Засгийн газрын ХИҮ байр. 3 давхар. 306 тоот өрөө.  
[www.energy.gov.mn](http://www.energy.gov.mn)